



ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ, ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ

2010 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 6177.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 53.5%-иар өсчээ. Гадаад худалдааны алдагдал өнгөрсөн оноос 50.1%-иар өсч 378.7 сая ам.долларт хүрсний зэрэгцээ, валютын төлбөртэй гадаад худалдаа алдагдалтай болж, 3.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

- Нийт экспортын 84.4% буюу 2448.2 ам.долларын бараа бүтээгдэхүүнийг Хятад улс руу экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 175.8%-иар өссөн дүн юм.

- Нийт импортын 33.3% буюу 1090.2 сая ам.долларын бараа бүтээгдэхүүнийг ОХУ-тай, 30.1% буюу 985.6 сая ам.долларын бараа бүтээгдэхүүнийг Хятад улстай тус тус хийжээ. Тус хугацаанд Монгол улс зэсийн баяжмал, чулуун нүүрс болон цайрын баяжмалыг 100% Хятад руу экспортолсон.


2010 оны 12 дугаар сарын хувьд гадаад худалдааны тэнцэл 58.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх сартай харьцуулахад 6.8%-иар буурсан боловч, өнгөрсөн оны 12 дугаар сартай харьцуулахад 12.5 дахин өссөн үзүүлэлт юм /Зураг 1/.

2010 оны дунджаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл¹ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.2%-иар сайжран 1.552-д хүрсэн. Үүнд, экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 40.3%-иар сайжран 4.656-д хүрсэн нь голлон нөлөөлжээ. Импортын үнийн индекс 22.6%-иар өсч 2.999-д хүрсэн ч, экспортын үнийн индексийн өсөлт нь 17.7 нэгжээр илүү байсан нь худалдааны нөхцөлд эерэгээр нөлөөлжээ. /Зураг 2/


Хүснэгт 1. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/

	Эхний 12 сар		Δ%
	2009	2010	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	4,023.1	6,177.1	53.5%
• Валютын төлбөртэй бараа	3,704.1	5,867.2	58.4%
Экспорт	1,885.4	2,899.2	53.8%
• Валютын төлбөртэй бараа	1,868.5	2,895.7	55.0%
Импорт	2,137.7	3,277.9	53.3%
• Валютын төлбөртэй бараа	1,835.7	2,971.5	61.9%
Гадаад худалдааны тэнцэл	-252.3	-378.7	50.1%
• Валютын төлбөртэй бараа	32.8	-75.9	

Зураг 1. Гадаад худалдааны эргэлт, сараар /сая ам.доллар/



Зураг 2. Худалдааны нөхцөл, сараар



ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭД²

¹ Экспортод дунджаар 90 орчим хувийг эзэлдэг 10 бүтээгдэхүүн, импортод дунджаар 88 орчим хувийг эзэлдэг 7 бүлэг бүтээгдэхүүний хувьд худалдааны нөхцөлийн индексийг 2000 оныг суурь болгон тооцов.

² Экспортын үнэ нь худалдааны түнш хооронд гэрээгээр тохирсон болон бүс нутгийн зах зээл дэх үнийг илэрхийлнэ.

2010 онд нийт 2899.2 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оноос 53.8% буюу 1013.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Тухайн хугацаанд нийт экспортын 30.2%-ийг чулуу нүүрс, 26.7%-ийг зэсийн баяжмал, 8.7%-ийн төмрийн хүдэр ба баяжмал, 6.1%-ийг мөнгөжөөгүй алт тус тус бүрдүүлж байна. Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ өнгөрсөн оноос 2.3 дахин, төмрийн хүдэр ба баяжмалын биет хэмжээ 2.2 дахин, боловсруулаагүй нефтийн биет хэмжээ 1.1 дахин өссөн. 2010 онд Монголбанк 0.9 тн, “Бороо Гоулд” ХХК 4.1 тн алт тус тус экспортолсон бол 2009 оны мөн үед Монголбанк 4.1 тн, “Бороо Гоулд” ХХК 5.4 тн алт тус тус экспортолж байжээ.

Мөнгөжөөгүй алт, ямааны угаасан, самнасан ноолуур, цайрын хүдэр ба баяжмалын биет хэмжээ буурснаар нийт экспорт 260.4 сая ам.доллараар буурахаар байсан ч, (i) чулуун нүүрс, (ii) төмрийн хүдэр, (iii) боловсруулаагүй нефть, (iv) жонш, лейцит, нефелинт сиенитийн экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 533.7 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүнүүд болон бусад эрдэс бүтээгдэхүүний экспортын үнийн өсөлтөөс шалтгаалан 678.0 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь экспорт өнгөрсөн оны мөн үеэс өсөхөд голлон нөлөөлжээ.

Зураг 4. Лондонгийн металлын бирж дээрх зэс, цайрын үнэ




2010 онд Монгол улсын экспортын гол түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өмнөх оны мөн үеэс өссөн байна. Тухайлбал, 2010 оны дунджаар Лондонгийн металлын бирж дээрх А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ 1.5 дахин өсч, тонн тутамд 7.556 ам.доллар, алтны үнэ 1.3 дахин өсч, унц тутамд 1237.7 ам.долларт хүрчээ. Мөн онд Өвөрмонголын нүүрсний дундаж үнэ 19.0%-иар өсч 53.3 ам.долларт, Монгол улсын экспортын нүүрсний дундаж үнэ 24.5%-иар өсч 50.8 ам.долларт тус тус хүрсэн.


Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 12 сар				Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/
	2009		2010		
	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	
1 Чулуун нүүрс	7,093,497	305.7	16,559,009	874.6	186.1% ↑
2 Зэсийн баяжмал	586,982	501.9	568,664	770.6	53.5% ↑
3 Төмрийн хүдэр ба баяжмал	1,598,123	88.8	3,539,320	250.9	182.7% ↑
4 Мөнгөжөөгүй алт	10,877	308.5	5,060	178.3	-42.2% ↓
5 Боловсруулаагүй нефть	1,938,541	115.6	2,078,682	154.9	34.0% ↑
6 Цайрын хүдэр ба баяжмал	150,737	122.5	119,789	134.1	9.5% ↑
7 Ямааны угаасан ноолуур	3,527	90.9	3,016	104.6	15.0% ↑
8 Ямааны самнасан ноолуур	1,623	68.4	977	68.8	0.7% ↑
9 Жонш, лейцит, нефелинт ба	314,017	48.2	376,049	63.2	31.0% ↑
10 Молибдений хүдэр ба баяжмал	6,652	50.3	4,769	52.0	3.3% ↑
Бусад		184.5		247.1	33.9% ↑
Нийт экспорт		1,885.4		2,899.2	53.8% ↑

Зураг 3. Экспортын үнийн болон тоо хэмжээний үнийн өөрчлөлт /сая ам.доллар/



Зураг 5. Чулуун нүүрсний зах зээлийн үнэ, сараар



2010 онд нийт 3277.9 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн импортоор оруулж ирсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 50.2% буюу 959.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Тухайн хугацаанд нийт импортын 20.7%-ийг нефтийн бүтээгдэхүүн, 16.7%-ийг хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл, 12.9%-ийг тээврийн хэрэгсэл тус тус бүрдүүлж байна. Нийт импортолсон нефтийн бүтээгдэхүүний 96.3%-ийг ОХУ-аас авсан байна.


Хүснэгт 3. Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 12 сар		Өөрчлөлт /хувийр/
	2009	2010	
1 Нефтийн бүтээгдэхүүн	527.9	678.0	28.4% ↑
2 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	279.5	546.2	95.4% ↑
3 Тээврийн хэрэгсэл	168.8	422.2	150.1% ↑
4 Хүнсний бүтээгдэхүүн	155.6	168.9	8.6% ↑
6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	82.7	114.2	38.1% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	41.1	63.5	54.4% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	60.4	22.8	-62.2% ↓
8 Төрөл бүрийн даавуу	1.5	1.7	14.7% ↑
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	92.7	124.2	34.0% ↑
Бусад	727.4	1,136.2	56.2% ↑
Нийт импорт	2,137.7	3,277.9	53.3% ↑


Төмөр хийц метал бүтээгдэхүүнээс бусад бараа бүтээгдэхүүний импортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан импорт 539.5 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүн хилийн дундаж үнийн өсөлтөөс шалтгаалан 231.8 сая ам.доллараар, бусад бараа бүтээгдэхүүний өсөлтөөс шалтгаалан 408.8 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Тус хугацаанд хүнд машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харгалзан 2.0, 2.5 дахин өсчээ.


Зураг 6. Импортын үнийн болон тоо хэмжээний үнийн өөрчлөлт /сая ам.доллар/



Зураг 7. Монгол улсын нефтийн импорт (сараар)



Зураг 8. Газрын тосны зах зээлийн үнэ³



Тайлант хугацаанд 678.0 сая ам.долларын нефтийн бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.4% буюу 150.1 сая ам.доллараар өссөн үзүүлэлт байна. Энэхүү өсөлтийн 27.8% нь импортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалсан бол үлдэгдэл 72.2% нь үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал, Уралын газрын тосны дундаж үнэ 2010 оны дунджаар өмнөх онтой харьцуулахад 29.4%-иар өсч, баррель тутамд 77.9 ам.долларт хүрсэн бол, мөн хугацаанд манай улсын импортын нефтийн бүтээгдэхүүний дундаж үнэ 18.6%-иар өсч тонн тутамд 796.8 ам.долларт хүрч, өсчээ.

Дүгнэлт: Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2010 оны эхний 12 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 50.1%-иар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 39.9%-иар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 36.5%-иар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

³ Эх сурвалж: АНУ-ын эрчим хүчний мэдээллийн агентлаг (www.eia.doe.gov), ОХУ-ын Уралын газрын тосны үнэ.